БЭЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ
Аудит, баталгаажуулалт, зөвлөх үйлчилгээ

Монгол Улс, Улаанбаатар хот-16066
Баянгол дүүрэг, Амарсанаагийн гудамж-5
Утас: 70005401, 70005402
Э.Шуудан: info@btdalaivanaudit.mn
Вэб хуудас: www.btdalaivanaudit.mn

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

"ДИ ЭМ ФИНАНС ББСБ" ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Санал дүгнэлт

Бид 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол бүхий нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн "Ди Эм Финанс ББСБ" ХХК-ийн санхүүгийн тайланд аудитыг хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр "**Ди Эм Финанс** ББСБ" ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого, зардал, үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн СЗХ болон СС-с хамтран баталсан нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах заавар, журмын дагуу үнэн зөв бодитоор илэрхийлэгдсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх, эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг "МНБ-ын ёс зүйн дүрэм"-г мөрдөж ажилласан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалтай бөгөөд зохистой гэж бид үзэж байна.

Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудал нь тайлант жилийн санхүүгийн тайланд аудитад хамгийн ихээр нөлөө үзүүлэхүйц зүйлс юм. Эдгээр асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын агуулгын хүрээнд бүхэлд нь болон энэ тайлангийн талаар аудиторын дүгнэлт гаргахад авч үзсэн бөгөөд аудитор энэхүү гол асуудалд тусад нь дүгнэлт илэрхийлээгүй болно. Аудитаар ийм асуудал илрээгүй болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон бидний аудиторын тайлан ордоггүй. Санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамардаггүй бөгөөд бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилтын дүгнэлт гаргахгүй.

"BAKER TILLY DALAIVAN AUDIT" LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

bakertilly
INTERNATIONAL

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН
(үргэлжлэл)

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй болно.

Санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудыг тодорхойлно.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийн талаар нэмэлт тодруулга хийнэ.

Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид дараах ажлуудыг хийсэн:

- ✓ Санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлсэн, мөн дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах зэрэг залилангаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.

- ✓ Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.

"BAKER TILLY DALAIVAN AUDIT" LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН
(үргэлжлэл)

- ✓ Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.

- ✓ Хэрэв компанийн тасралтгүй байх чадавхад материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт бид анхаарлаа хандуулах болно. Хэрэв энэ талаар холбогдох тодруулгад хангалттай дурдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд компанийн тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсэж болох юм.

- ✓ Санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.

Бид засаглах удирдлагатай аудитын цар хүрээ, хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар харилцсан.

Хэрэглээний хязгаарлалт

Энэхүү тайланг Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигчид зориулан бэлтгэсэн ба тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч талын өмнө ямар нэгэн хариуцлага хүлээхгүй болно.

УЛААНБААТАР ХОТ
2018365 СТА2959 9020120099

БЭЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ УЛС

2025 ОНЫ 02 ДУГААР
САРЫН 12-НЫ ӨДӨР

ДИ ЭМ ФИНАНС ББСБ

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон жилийн

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

мянган төгрөг

ҮЗҮҮЛЭЛТ	2024.12.31	2023.12.31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	44,837.5	72,970.2
Үнэт цаас		
Зээл /цэвэр үлдэгдэл/	4,115,131.1	2,707,607.1
Хуримтлуулж тооцсон хүүний авлага	332,799.0	
Бусад санхүүгийн хөрөнгө	189,696.4	117,802.3
Бусад хөрөнгө		
Эргэлтийн хөрөнгийн дүн	**4,682,464.0**	**2,898,379.6**
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	710,071.3	670,950.3
Биет бус хөрөнгө		
Урт хугацаат хөрөнгө оруулалт		
Биологийн хөрөнгө		
Хойшлогдсон татварын хөрөнгө		
Бусад эргэлтийн бус хөрөнгө		
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	*710,071.3*	*670,950.3*
Нийт хөрөнгийн дүн	**5,392,535.3**	**3,569,329.9**
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Банк, санхүүгийн байгууллагаас авсан богино хугацаат зээл	1,832,718.1	828,618.0
Өрийн бичгээрх өглөг		
Бусад өр төлбөр	72,503.3	53,849.5
Бусад өглөг		
Богино хугацаат өр төлбөрийн дүн	*1,905,221.4*	*882,467.5*
Урт хугацаат зээл		
Хойшлогдсон татварын өр		
Бусад урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	
Нийт өр төлбөрийн дүн	**1,905,221.4**	**882,467.5**
Эзэмшигчдийн өмч		
Өмч: Энгийн хувьцаа	1,200,000.0	1,200,000.0
Хандивын капитал		
Нийгмийн хөгжлийн сан		
Хуримтлагдсан ашиг	2,287,313.9	1,486,862.4
Эзэмшигчдийн өмчийн дүн	*3,487,313.9*	*2,686,862.4*
Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	**5,392,535.3**	**3,569,329.9**
	-	-

Хавсаргасан тайлангууд нь энэхүү хараат бус аудиторын дүгнэлтийн салшгүй хэсэг болно.

"BAKER TILLY DALAIVAN AUDIT" LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

ОРЛОГО ҮР ДҮН БОЛОН БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

мянган төгрөг

ҮЗҮҮЛЭЛТ	2024.12.31	2023.12.31
Хүү болон түүнтэй адилтгах орлого	1,279,365.7	846,411.1
Хүүний зардал	212,105.0	126,169.0
Нийт ашиг	***1,067,260.7***	***720,242.1***
Хүүний бус орлого	76,437.0	50,512.2
Хүүний бус зардал	214,278.4	159,785.0
Боловсон хүчинтэй холбоотой зардал	88,807.3	
Бусад зардал	125,471.1	
Эрсдэлийн сангийн зардал	7,751.2	3,242.2
Үйл ажиллагааны ашиг	**921,668.1**	**607,727.1**
Үндсэн бус үйл ажиллагааны орлого		
Үндсэн бус үйл ажиллагааны зардал		
Татварын өмнөх ашиг	**921,668.1**	**607,727.1**
Орлогын албан татварын зардал	9,216.6	6,077.3
Тайлант жилийн татварын дараах ашиг	**912,451.5**	**601,649.8**
Бусад дэлгэрэнгүй орлого:		
Эрсдэлийн сангийн нөөцийн (өсөлт), бууралт		
Нийгмийн хөгжлийн сангийн (өсөлт), бууралт		
Нийт бусад дэлгэрэнгүй орлого	**912,451.5**	**601,649.8**

Хавсаргасан тайлангууд нь энэхүү хараат бус аудиторын дүгнэлт, тайлангийн салшгүй хэсэг болно.

"BAKER TILLY DALAIVAN AUDIT" LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

мянган төгрөг

ҮЗҮҮЛЭЛТ	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	**Нийт дүн**
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	**1,200,000.0**		**-**		**885,212.6**	**2,085,212.6**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						
Залруулсан үлдэгдэл	**1,200,000.0**		**-**	**-**	**885,212.6**	**2,085,212.6**
Тайлант үеийн цэвэр ашиг					601,649.8	**601,649.8**
Бусад дэлгэрэнгүй орлого						
Өмчид гарсан өөрчлөлт						
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт (бууралт)						
Ногдол ашиг						-
2023 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	**1,200,000.0**		**-**	**-**	**1,486,862.4**	**2,686,862.4**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						-
Залруулсан үлдэгдэл	**1,200,000.0**		**-**	**-**	**1,486,862.4**	**2,686,862.4**
Тайлант үеийн цэвэр ашиг					912,451.5	**912,451.5**
Өмчид гарсан өөрчлөлт						
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт (бууралт)						
Ногдол ашиг					(112,000.0)	**(112,000.0)**
2024 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	**1,200,000.0**		**-**	**-**	**2,287,313.9**	**3,487,313.9**

Хавсаргасан тайлангууд нь энэхүү хараат бус аудиторын дүгнэлт, тайлангийн салшгүй хэсэг болно.

"BAKER TILLY DALAIVAN AUDIT" LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

мянган төгрөг

Үзүүлэлт	2024.12.31	2023.12.31
1.ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	**338,354.6**	**(545,081.8)**
1.1 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	**7,514,135.7**	**6,581,551.2**
Зээл, хүүний төлбөрт хүлээн авсан орлого	5,850,716.4	6,580,331.5
Итгэлцлийн үйлчилгээнээс хүлээн авсан	1,654,300.6	
Банкин дахь хадгаламжийн хүүний орлого		
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	9,118.7	1,219.7
1.2 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	**7,175,781.1**	**7,126,633.0**
Үндсэн ба нэмэгдэл цалин	71,452.5	76,592.0
Татвар, нийгмийн даатгалын байгуулагад төлсөн мөнгө	123,881.4	69,947.0
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	2,606.8	2,297.2
Шатахуун, холбоо, интернет, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө		
Бичиг хэргийн зардал, ариун цэврийн зардал		
Татвар, даатгалд төлсөн мөнгө		
Ногдол ашгаар олгосон мөнгө		
Зээл болон түүнтэй холбоотой авлага барагдуулахтай холбоотой гарсан зардал		
Факторингийн үйл ажиллагаагаар шилжүүлсэн	397,830.0	
Буцаан олгосон итгэлцэл, үр шим	701,798.9	
Олгосон зээл	5,836,470.7	5,067,634.0
Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө	41,740.8	1,910,162.8
2.ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	**(366,487.3)**	**(90,000.0)**
2.1 Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого	**5,724,526.4**	
Банк санхүүгийн байгуулагаас хүлээн авсан зээл	5,724,526.4	
Ногдол ашгийн орлого		
Бусад		
2.2 Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага	**6,091,013.7**	**90,000.0**
Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	47,365.8	
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	15,798.5	
Банк санхүүгийн байгуулагад төлсөн зээл	5,927,049.4	
Төлсөн ноогдол ашиг	100,800.0	90,000.0
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	**(28,132.7)**	**(635,081.8)**
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	**72,970.2**	**708,052.0**
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	**44,837.5**	**72,970.2**

Хавсралсан тайлангууд нь энэхүү хараат бус аудиторын дүгнэлт, тайлангийн салшгүй хэсэг болно

"GOBI VALLEY DALAIVAN AUDIT" LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL